



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/092/НА-СТА-ОНӨҮГ

| | |
|--|--|
| Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он | Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эвиденсе аудит ХХК-ийн захирал: С.Бадамгарав Утас: 70007121 Цахим хаяг: info@evidenceaudit.mn |
|--|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 01/264
танай _____-ны № _____-т

УЛААНБААТАР ЗАМ ЗАСВАР,
АРЧЛАЛТЫН ГАЗАР
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Б.ГАЛХҮҮ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Замын сангийн хөрөнгөөс 32,762,848.6 мянган төгрөг, Нийслэлийн Засаг даргын нөөц сангаас 3,605,462.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 24 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд 39,439,447.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 39,396,571.5 мянган төгрөгийн зардал гарган, 36,797.0 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд Нийслэлийн Засаг даргын тамгын газартай 13 гэрээт ажил, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албатай 29 гэрээт ажил, Нийслэлийн Авто замын хөгжлийн газартай 11 гэрээт ажил хийж гүйцэтгэн 95.0 хувийн гүйцэтгэлтэй хүлээлгэн өгсөн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---------------|---------------------------------------|--------------------------|--------------------------|
| 1.1.01 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 3,699,938,373.98 | 2,280,757,185.23 |
| 1.1.02 | Дансны авлага | 4,079,872,012.81 | 30,576,690,987.83 |
| 1.1.03 | Татвар, НДШ-ийн авлага | 5,000,182.76 | 158,399.62 |
| 1.1.04 | Бусад авлага | 2,630,002,891.00 | 2,182,841,930.50 |
| 1.1.06 | Бараа материал | 2,635,185,066.01 | 4,946,954,070.88 |
| 1.1.07 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 0.00 | 5,712,972,727.27 |
| 1.1.08 | Бусад эргэлтийн хөрөнгө | 14,474,973.67 | 18,821,566.83 |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 13,064,473,500.23 | 45,719,196,868.16 |
| 1.2.01 | Үндсэн хөрөнгө | 4,037,504,520.95 | 3,348,792,800.39 |
| 1.2.02 | Биет бус хөрөнгө | 32,739.05 | 0.00 |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 4,037,537,260.00 | 3,348,792,800.39 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 17,102,010,760.23 | 49,067,989,668.55 |
| 2.1.1.01 | Дансны өглөг | 1,015,071,643.18 | 462,014,103.52 |
| 2.1.1.03 | Татварын өр | 3,871,811,268.61 | 4,520,965,988.85 |
| 2.1.1.08 | Урьдчилж орсон орлого | 944,924,832.79 | 33,058,048,179.09 |
| 2.1.1.09 | Нөөц /өртөлбөр/ | 2,161,051,129.48 | 1,802,432,703.17 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 5,553,992.10 | 84,133,760.10 |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 7,998,412,866.16 | 39,927,594,734.73 |
| 2.3.01 | Өмч: - төрийн | 7,765,127,992.86 | 7,765,127,992.86 |
| 2.3.06 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 1,167,698,193.21 | 1,167,698,193.21 |
| 2.3.09 | Хуримтлагдсан ашиг | 170,771,708.00 | 207,568,747.75 |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 9,103,597,894.07 | 9,140,394,933.82 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 17,102,010,760.23 | 49,067,989,668.55 |

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---------------|--|--------------------------|--------------------------|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 43,162,619,525.46 | 39,395,058,567.14 |
| 2 | Борлуулалтын өртөг | 42,062,391,424.73 | 37,943,637,657.84 |
| 3 | Нийт ашиг(алдагдал) | 1,100,228,100.73 | 1,451,420,909.30 |
| 4 | Хүүгийн орлого | 34,953,948.09 | 20,606,410.86 |
| 5 | Бусад орлого | 378,197,121.64 | 23,782,131.11 |
| 6 | Ерөнхий ба удирдлагын зардал | 1,391,843,258.75 | 1,196,243,091.80 |
| 7 | Санхүүгийн зардал | 3,495,926.90 | 1,874,523.18 |
| 8 | Бусад зардал | 70,697,597.00 | 254,816,269.90 |
| 9 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 0.00 | 0.00 |
| 10 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | 47,342,387.81 | 42,875,566.39 |
| 11 | Орлогын татварын зардал | 6,505,554.69 | 6,078,526.64 |
| 12 | Татварын дараах ашиг (алдагдал) | 40,836,833.12 | 36,797,039.75 |
| 13 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 40,836,833.12 | 36,797,039.75 |

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|--|-------------------------|-------------------------------------|-----------------------|-------------------------|
| 2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл | 7,859,113,826.92 | 1,167,698,193.21 | 129,934,874.88 | 9,156,746,895.01 |
| Өмчид гаргасан өөрчлөлт | (93,985,834.06) | - | - | (93,985,834.06) |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | 40,836,833.12 | 40,836,833.12 |
| 2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл | 7,765,127,992.86 | 1,167,698,193.21 | 170,771,708.00 | 9,103,597,894.07 |
| Залруулсан үлдэгдэл | 7,765,127,992.86 | 1,167,698,193.21 | 170,771,708.00 | 9,103,597,894.07 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | 36,797,039.75 | 36,797,039.75 |
| 2024 оын 12 сарын 31-р үлдэгдэл | 7,765,127,992.86 | 1,167,698,193.21 | 207,568,747.75 | 9,140,394,933.82 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---------------|---|--------------------------|--------------------------|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 45,873,371,370.89 | 49,669,515,132.48 |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 45,793,441,917.34 | 49,648,150,766.31 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 79,929,453.55 | 21,364,366.17 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 45,604,467,770.90 | 51,109,302,732.09 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 2,354,746,698.82 | 2,456,391,154.00 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 770,236,152.48 | 745,987,210.00 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 38,864,867,785.13 | 46,468,328,402.96 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 98,118,253.37 | 89,672,991.42 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 2,146,209,934.00 | 2,820,000.00 |
| 1.2.6 | Хүүний төлбөрт төлсөн | 0.00 | 0.00 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 664,376,925.23 | 344,027,061.09 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 26,476,234.00 | 9,822,127.00 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 679,435,787.87 | 992,253,785.62 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 268,903,599.99 | -1,439,787,599.61 |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 0.00 | 20,606,410.86 |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | 0.00 | 20,606,410.86 |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 424,572,587.27 | 0.00 |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 424,572,587.27 | 0.00 |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | -424,572,587.27 | 20,606,410.86 |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 0.00 | 0.00 |
| 3.1.4 | Бусад | 0.00 | 0.00 |
| 3.2.5 | Бусад | 0.00 | 0.00 |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 0.00 | 0.00 |
| 4 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | -155,668,987.28 | -1,419,181,188.75 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 3,855,607,361.26 | 3,699,938,373.98 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 3,699,938,373.98 | 2,280,757,185.23 |

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөг/

| № | Үзүүлэлт | 2023 оны гүйцэтгэл | 2024 он | | | |
|-------------------------|---|---------------------|---------------------|---------------------|-----------------------|--------------|
| | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| 1 | Авто зам, замын байгууламж барих, засвар, арчлалтын газар | 36,382,872.3 | 13,730,897.3 | 34,033,252.3 | (20,302,354.9) | 247.9 |
| 2 | Авто замын тэмдэг тэмдэглэгээний ажил | 3,116,895.2 | | 2,823,342.8 | (2,823,342.8) | |
| 3 | Хайс, хашлаганы засвар арчлалт | 2,197,638.4 | | 1,038,227.60 | (1,038,227.6) | |
| 4 | Гүүрийн байгууламж, нүхэн гарцны ашиглалт үйлчилгээ | 449,095.4 | | 395,717.8 | (395,717.8) | |
| 5 | Асфальт, бетон хольц үйлдвэрлэлийн орлого | 766,690.2 | 300,000.0 | 1,022,691.3 | (722,691.3) | 340.9 |
| 6 | Төлбөртэй авто зогсоолын орлого | 326,956.5 | | 17,253.0 | (17,253.0) | |
| 7 | Бусад орлого | 335,622.6 | | 108,962.30 | (108,962.3) | |
| Нийт орлогын дүн | | 16,723,334.0 | 14,030,897.3 | 39,439,447.1 | (25,408,549.8) | 281.1 |
| 1 | Цалин | 2,806,524.6 | 3,342,213.4 | 2,913,875.0 | 428,338.4 | 87.2 |
| 2 | Хоол унааны хөнгөлөлтийн зардал | 197,744.8 | 324,720.0 | 188,271.0 | 136,449.0 | 58.0 |
| 3 | Нийгмийн даатгалын шимтгэл | 770,396.6 | 531,705.3 | 404,382.4 | 127,322.9 | 76.0 |
| 4 | Удирдах зөвлөлийн зардал | 33,000.0 | | 29,700.0 | (29,700.0) | |
| 5 | Сэлбэг хэрэгсэл | 351,572.5 | 192,022.6 | 239,738.0 | (47,715.4) | 124.8 |
| 6 | Ашиглалтын зардал | 80,135.9 | 83,400.0 | 123,481.7 | (40,081.7) | 148.0 |
| 7 | Түрээсийн зардал | 413,768.1 | 150.0 | 680,831.3 | (680,681.3) | 453.9 |
| 8 | Тос, тосолгооны зардал | 84,436.8 | 36,551.0 | 81,406.60 | (44,855.60) | 222.7 |
| 9 | Хөдөлмөр хамгааллын зардал | 41,987.6 | 35,310.0 | 53,490.00 | (18,180.00) | 151.4 |
| 10 | Түүхий эд материал | 16,719,203.7 | 5,322,390.0 | 3,468,401.5 | 1,853,988.5 | 65.2 |
| 11 | Урсгал засварын зардал | | 25,000.0 | 13,698.9 | 11,301.1 | 54.8 |
| 12 | Шатахуун | 2,146,209.9 | 2,142,300.0 | 1,306,417.7 | 835,882.3 | 60.9 |
| 13 | Шуудан холбоо, бичиг хэрэгсэл | 53,428.5 | 27,343.0 | 15,857.4 | 11,485.6 | 57.9 |
| 14 | Сургалт | 8,253.7 | 9,740.0 | 17,890.0 | (8,150.0) | 183.7 |
| 15 | Үндсэн хөрөнгийн элэгдэл | 553,533.4 | 572,727.9 | 869,637.5 | (296,909.7) | 151.9 |
| 16 | Албан журмын даатгал, татвар | 26,156.2 | 33,500.0 | 24,927.2 | 8,572.8 | 74.0 |
| 17 | Хангамж материал | 43,841.1 | 41,737.3 | 40,432.9 | 1,304.4 | 96.8 |

| | | | | | | |
|-------------------------|--|---------------------|---------------------|---------------------|-----------------------|--------------|
| 18 | Нийгмийн арга хэмжээний зардал | 39,537.8 | 192,689.0 | 189,610.50 | 3,078.5 | 98.4 |
| 19 | Ахмадын сан | 11,560.0 | 33,422.0 | 33,583.0 | (161.0) | 100.5 |
| 20 | Төлбөрт үйлчилгээний зардал | 123,206.4 | | | | |
| 21 | Он дамнасан ажлын Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал | 2,500,000. | 600,000.0 | 28,655,142.2 | (28,055,142.2) | 4,775. |
| 22 | 2024 оны гэрээт ажлын Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал | 16,427,828.6 | 350,000.0 | | 350,000.0 | - |
| 23 | Гамшгийн үеийн менежментийн зардал | 16,102.0 | 24,895.0 | 23,560.0 | 1,335.00 | 94.6 |
| 24 | Үйл ажиллагааны бус зардал | 80,000.0 | 60,000.0 | 22,236.70 | 37,763.3 | 37.1 |
| Нийт зардлын дүн | | 16,699,163.9 | 13,981,816.5 | 39,396,571.5 | (25,414,755.0) | 281.8 |
| 25 | Татварын өмнөх ашиг | 47,342.4 | 49,081.2 | 42,875.6 | 6,205.6 | 87.4 |
| 26 | Орлогын татвар | 6,505.6 | 4,909.1 | 6,078.6 | (1,169.5) | 123.8 |
| 27 | Цэвэр ашиг алдагдал | 40,836.8 | 44,172.10 | 36,797.0 | 7,375.1 | 83.3 |

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 418,275.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 2 албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|-------------|------------------|----------------|-----|-----------------|------------------|---------|-----|
| | | | Төлбөр ийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ажиллагсадтай холбоотой авлага, өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ аваагүй, үлдэгдлийн тооцоо хийж, баталгаажуулаагүй | 1 | 10,346.1 | | | 1 | 10,346.1 | | |
| Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй | 1 | 407,929.5 | | | 1 | 407,929.5 | | |
| Дүн | 2 | 418,275.6 | | | 2 | 418,275.6 | | |

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|--------------------|---------------|-----|-----------------|-----|----------|--------------------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд 4 нэр төрлийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан | 1 | 730,912.4 | | | | | 1 | 730,912.4 |
| Дүн | 1 | 730,912.4 | | | | | 1 | 730,912.4 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Албан хэрэгцээнд бараа, үйлчилгээг цахим дэлгүүрээс худалдан аваагүй | 1 | 2,315,762.6 | | | | | 1 | 2,315,762.6 |
| Дүн | 1 | 2,315,762.6 | | | | | 1 | 2,315,762.6 |
| Нийт дүн | 2 | 3,046,675.0 | | | | | 2 | 3,046,675.0 |

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| | | | Санал дүгнэлт гаргас | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | | | | |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | | | | | | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | 1 | | | 1 | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | НИЙТ | | 1 | | | 1 | | | |